



СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,  
ДОТООД АУДИТЫН ГАЗАР  
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧИЙН  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 05 сарын 29 өдөр

Дугаар 04/32-01

Сүхбаатар сум

**Зөрчил арилгуулах тухай**

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.9 дэх хэсэгт заасан хяналт шалгалтын байгууллага (Улсын байцаагч)-ын бүрэн эрхийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар нь аймгийн Засаг даргын 2026 оны 04 дугаар сарын 24-ны өдрийн ДА-2025/11/ҮА-ТТЗ дугаартай удирдамжийн дагуу Сэлэнгэ аймгийн Баянгол сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 он, 2025 оны үйл ажиллагааны үр дүнд хийсэн аудитаар сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 2025 онд хэрэгжүүлж буй 2 төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн баталгаа 15,592,559 (Арван таван сая таван зуун ерэн хоёр мянга таван таван зуун тавин ес) төгрөгийг захиалагчид хүргүүлээгүй, 8 төсөл арга хэмжээний чанарын баталгаа 30,268,976 (Гучин сая хоёр зуун жаран найман мянга есөн зуун далан зургаа) төгрөгийг гаргуулаагүй, нийт 10 төсөл арга хэмжээний 45,861,535 (Дөчин таван сая найман зуун жаран нэгэн мянга таван зуун гучин тав) төгрөгийн зөрчил илэрлээ. Үүнд:

Гүйцэтгэлийн баталгааг гаргуулалгүй:

- Халаалтын төвд уурын зуух шинээр худалдаж авах төсөл арга хэмжээнд гүйцэтгэгчээр шалгарсан Гом илч ХХК-тай 299,952,250.0 төгрөгийн гэрээ байгуулахдаа үнийн дүнгийн 3 хувь болох 8,998,568.0 төгрөг,
- Хүүхдийн тоглоомын талбай төсөл арга хэмжээнд гүйцэтгэгчээр шалгарсан Хүрэл соёмбо ХХК-тай 219,799,700.0 төгрөгийн гэрээ байгуулахдаа үнийн дүнгийн 3 хувь болох 6,593,992 төгрөг,

Чанарын баталгааг аваагүй:

- Хүүхдийн тоглоомын талбай 219,799,700.0 төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл арга хэмжээний гүйцэтгэгч Хүрэл соёмбо ХХК-аас чанарын баталгаа 5 хувь болох 10,989,987.0 төгрөг,
- Үер усны аюулаас сэргийлэх /Аврах завь мотор багаж хэрэгсэл худалдаж авах/ 35,000,000.0 төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл арга хэмжээний гүйцэтгэгч Нанопланет ХХК-аас чанарын баталгаа 5 хувь болох 1,750,000.0 төгрөг,
- Зохиомол хээлтүүлэг хийх багаж эхо аппарат худалдаж авах 45,000,000.0 төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл арга хэмжээний

4326007029

гүйцэтгэгч Атар ирээдүй ХХК-аас чанарын баталгаа 5 хувь болох 2,250,000.0 төгрөг,

- Худаг шинээр гаргах 60,000,000.0 төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл арга хэмжээний гүйцэтгэгч Атар ирээдүй ХХК-аас чанарын баталгаа 5 хувь болох 3,000,000.0 төгрөг,
- Хонь хяргах төхөөрөмжийг цахилгааны эх үүсвэртэй худалдаж авах 60,000,000.0 төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл арга хэмжээний гүйцэтгэгч Атар ирээдүй ХХК-аас чанарын баталгаа 5 хувь болох 3,000,000.0 төгрөг,
- Өтөг бууц цэвэрлэх бага оврын ковш худалдаж авах 60,000,000.0 төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл арга хэмжээний гүйцэтгэгч Атар ирээдүй ХХК-аас чанарын баталгаа 5 хувь болох 3,000,000.0 төгрөг,

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д “Тендер шалгаруулалтын төсөвт өртөг 100 сая төгрөгөөс дээш бол гэрээний үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гүйцэтгэлийн баталгаа шаардана”, 42.5-д. “Бараа, ажил, үйлчилгээний чанарын баталгаа болон зүгшрүүлэх, тохируулах хугацаанд гүйцэтгэгчийн хүлээсэн үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор захиалагч худалдан авах гэрээний үнийн дүнгийн 5-10 хувийг барьцаалах нөхцөлийг тендер шалгаруулалтын баримт бичигт тусгаж болно”. Сангийн сайдын 2023 оны А/252 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-ын 3.1 дэх “Хуулийн 42.1-д зааснаас дээш төсөвт өртөгтэй тендер шалгаруулалтад гэрээ байгуулах эрх авсан оролцогч тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаас багагүй үнийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг захиалагчид хүргүүлнэ” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.9.8-д “Хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг таслан зогсоох, түүний шалтгаан нөхцөлийг арилгах талаар холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, иргэн, албан тушаалтанд шаардлага тавьж, хугацаатай үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулах”, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 7 дугаар зүйлийн 7.5-д “Санхүүгийн хяналт шалгалтын улсын (ахлах) байцаагч нь шалгалтаар тогтоосон ажлын үр дүн, зөрчил, түүнийг арилгах талаар цаашид авах арга хэмжээг тодорхойлсон шалгалтын тэмдэглэл, санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль тогтоомж зөрчсөн албан тушаалтны төлөх торгууль, төлбөрийг заасан нэг бүрчилсэн акт, албан шаардлага бичнэ.” гэсэн заалтуудыг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Цаашид дээрх зөрчлийг дахин давтан гаргахгүй ажиллаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газарт ирүүлэхийг Баянгол сумын Засаг дарга Н.Давааням, Ерөнхий нягтлан бодогч Г.Баясгалан нарт даалгав.
2. Улсын ахлах байцаагчийн албан шаардлагыг тогтоосон хугацаанд биелүүлээгүй тохиолдолд Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.

3. Энэхүү албан шаардлагыг эс зөвшөөрвөл Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1-т заасны дагуу хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 30 хоногийн дотор эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНХҮҮГИЙН  
ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН  
ГАЗРЫН ДАРГА, САНХҮҮГИЙН  
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УЛСЫН  
АХЛАХ БАЙЦААГЧ



Т.ОДСҮРЭН

ЗӨВШӨӨРСӨН:

СЭЛЭНГЭ АЙМГИЙН БАЯНГОЛ  
СУМЫН ЗАСАГ ДАРГА

Н.ДАВААНЯМ

ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ

Г.БАЯСГАЛАН

2 \*250 \*000.0 ~~...~~

~~...~~

- ~~• ...~~

~~...~~

~~...~~

- ~~• ...~~

~~...~~

- ~~• ...~~

~~...~~

~~...~~

- ~~• ...~~

~~...~~

~~...~~

- ~~• ...~~

~~...~~

~~...~~

~~...~~

~~...~~

~~...~~

~~...~~

~~...~~

~~...~~

~~...~~

~~...~~

...

...

...

...



...  
...  
...



